

I. Франц дахи монголын судлал¹

Ц. Шагдарсүрэн

I. 1. Францад монголын судлал үүссэн түүхэн нөхцөл

Монголын судлал (МС) дорно дахинаа Хан (Han: III-II B.C. – A. D. II) улсын үед үүссэн гэдэг бол өрнө дахинаа XIII зуунд Францад буй болсон гэж үзэх бүрэн үндэслэлтэй.

Их Монгол улс байгуулагдаж улмаар тухайн үеийн олон улсад баримтлаж байсан элчийн харилцааны ёсзүйг зөрчисөний учир 1219 оноос Хорезмийг дайлсан үеэс Монгол болон Чингисийн тухай сураг занги Европ дахин, тэр дундаа Францын анхааралыг үлэмжхэн татах болж монголчууд болон Чингис хааныг Претер Джон (францаар Le Prêtre Jean)-ы домогтой холбон сонирхоход хүргэжээ.

Тухайн үеийн Монголчуудын тухайд Европ дахин янз янзаар үнэлэж, үлэмжхэн нөлөө бүхий Ромын пап II Фредерих тэргүүтэй шашины бөлөгийнхин болон германы ноёдууд хүчээ нэгэдхэн дайлж шашин сурталдаа оруулах бодолтой байсан боловч IX Лүй тэргүүтэй францын ноёд хүлээцтэй аядуу хандаж түүхэн нөхцөл байдалыг тандан ойлгох эрмэлзэлтэй байсан бөлгөө. Үүний дүнд ч 1245 онд Ромын пап IV Инносентийн санаачилгаар Монгол руу хоёр замаар элч илгээсэний нэг нь Францын Лион хотоос гарсан. Папын албан захидалыг Монголд хүргэж, Гүюгийн хариу захидалыг [*Уг захидал одоо Ватиканы нууц архивт буй.*] Папад барьсан, замын тэмдэглэлдээ үндэслэн "*Монголчуудын түүх*" хэмээх гайхамшигт номоо туурвиж Монголчуудыг Европ дахинд анх тодорхой танилцуулсан, бидний сайн мэдэх План Карпин (Jean de Plan Carpin) байсан билээ. Энэхүү үйл явдал нь чухамдаа Франц Монгол хоёр ороны албан харилцааны эхийг тавьсан юм. Уламаар 1253 онд Францын IX Лүй хаан, Монголоор явсан тэмдэглэлдээ үндэслэн "*Монгол гүрэнээр аялсан нь*" хэмээх ном бичсэн Гийом де Рубрук (Guillaume de Roubrouck)-ийг элчээр тусхайлан зарж Монголын Мөнх хаантай холбоо тогтоосон байх бөгөөд Мөнхийн дараа үеэс Франц гол харилцаагаа

¹ Энэхүү өгүүлэлийг БНХАУ-д гарах "*Дэлхийн Монголын судлал*" хэмээх нэвтэрхий толийн захиалгаар бичиж эрдэмтэд хийгээд холбогдох бүтээлийн гэрэл зурагийг хавсаргасанаас гадна тодорхой эрдэмтэн, байгуулга хийгээд тогтмол хэвлэлийн талаар тусхай есөн зурвас өгүүлэл дагалдуулсан бөлгөө.

Ил хааны улс руу хандуулан Хүлэгү, Абага, Аргун, Гасан, Өлзийт нартай удаа дараалан харилцасаар ирсэн баримт одоо хүртэл уг эхээрээ Парис, Ватикан, Вена, Техеран хотын архивт хадгалагдсаар байна.

Ийнхүү Францын хаадын хүчин зүтгэлээр нэгэнт тогтсон тогтвортой харилцааны дүнд зөвхөн улс төр төдийгүй монголчуудын хэл бичиг, түүх соёлыг сонирхон судлах шаардалга, боломж францад буй болсон юм.

1. 2. Францад хадгалагдаж буй Монгол болон монголчуудтай шууд холбогдох ховор нандин биет баримт сэлтээс

1. 2. 1. Францын Гоо Филиппэд 1295 онд ил хаан Аргун, 1305 онд ил хаан Өлзийтээс илгээсэн хоёр албан захидал (181 см х 25 см, 300 см х 51 см)-ын эх Франц Улсын архивт хадгалагдаж байна. Энэхүү хоёр захидал нь Франц Монгол хоёр ороны харилцааны баримт болохын хажуугаар Монголын гадаад бодолго, түүний өөрчлөлт хийгээд монгол хэл болон монгол бичигийн түүхэн чухал дурасгал болдог юм.

Эхиний захидалд цэрэг дайны эвсэлийн асуудал зонхилож байсан бол дараагийнхид нь эв найрамдал, амар амгаланд түлхүү анхаарсан байх бөгөөд Польшийн монголч эрдэмтэн В. Котвич уг хоёр баримтыг харьцуулан судлаад “*XIII зуунд Монголчууд дэлхий нийтийн энх тайвангийн санааг анх үүсгэсэн*” гэдэг дүгнэлтийг хийжээ. Энэ баримтыг үндэслэж Монголын түүхэнд “*Pax Mongolica*” буюу “**Монголын амгалан төр**”, “*The Mongol tolerance*” буюу “**Монголын хүлцэмж**” гэх зэрэг тусхай нэр томъёо буй болж эл сэдэвийг олон орны эрдэмтэд судлаж бие даасан ном өгүүлэл нэг бусыг бичжээ. Гэвч уг санаа үүнээс өмнө буюу Өгөөдэйн үеэс эхлэж, бас 1265 онд Хубилай хаанаас Японы ванд илгээсэн албан захидалд бас байдаг юм.

1. 2. 2. Мөн архивт 1289 оны Аргуны захидалыг хүргэж барьсан Бускарел (Buscarel) элчийн албан тэмдэглэл буй. Энэ хэр түүнийг сайтар судласан зүйл гараагүй.

1. 2. 3. Францын олон номын сан, музей тэргүүтэний сан хөмөргийн дотор, бүридхэлд орсон болоод орж амжаагүй олон зүйл буйн дотор монголын соёлд шууд холбогдол бүхий үнэт чухаг баримт нэг бус буй. Үүний нэг нь Францын Улсын номын санд буй “*...Таслагч очир*” хэмээх тод барын номын нэг мод болно. Нэгэн үе монголч эрдэмтэд тод бичигээр барласан ном байдаггүй хэмээн үзэж байсан боловч одоо лавтай баримтаар хэдэн араваас хэдэн зуун хуудас бүхий их бага арав гаруй ном барласан нь тодорхой болсон хэдий ч тэдгээр номын бар-мод хараахан олдоогүй байсан бөлгөө. Иймд энэхүү барын мод нь монголчуудын ном хэвлэлийн түүхэнд чухал нэгэн биет баримт болж өгнө.

1. 2. 4. Францын Хятад судлалын хүрээлэнгийн номын сан (La Bibliothèque de l'Institut des Hautes Etudes Chinoises)-гаас хэдэн жилийн өмнө тодорхой товъёг бүридхэлгүй, зураг чимэглэл бүхий монгол бичигээрхи нэгэн хуйлмал бичиг олдсон бөгөөд 1808 онд IX Далай лам Лүндогжамц (1805-1815)-ыг ширээнд залсан хийгээд түүний эхиний нэгэн жилийн үйл ажиллагаа, аялал тэргүүтэний албан тэмдэглэл болох энэхүү баримтыг түүх-эхбичиг болон урлагийн талаас нь францын монголч эрдэмтэн Марие-Доминик Эвэн (Marie-Dominique Even), Гайэл Лаказ (Gaelle Lacaze), Изабэл Шарло (Isabelle Charleux) нар тусхайлан судлаж хоёр томоохон өгүүлэл нийтлүүлжээ.

I. 2. 5. Францын Улсын Номын Сангийн Монгол гар бичмэл, модон барын хөмрөгт албан ёсны жагсаалтаар 175 нэгж зүйл байгаа бөгөөд үүнд К. Ф. Голстунскийн тольд үндэслэж Абель Ремюза (Abel Rémusat)-гийн зохиосон “*Монгол герман франц толь*”-ийн гар бичимэл эх байгаа нь франц дахи монголын судлалын түүхэнд нандин хадгалагдахуун болж байгаа юм.

I. 3. Франц дахи монголын судлал

I. 3. 1. Франц дахи монголын судлалын бэлэдхэл үе

Аливаа шинжлэх ухааны салбар үүсэхэд урьдчилсан буюу бэлэдхэл үе зайлашгүй байдагчилан Францад монголын судлал хөгжихөд мөн тийм үе байжээ. Энэ үе нь Францад Монголыг сонирхох болсон цагтай давхацах бөгөөд гол төлөв Монгол хийгээд Монголчуудын гарал, Чингистэй холбогдох мэдээ баримтыг цуглуулахаас эхлэсэн байдаг. Тухайлбал: Түүхийн салбар гэхэд: IX Лүй хааны шадар туслагч Жан Сир де Жуанвиль (Jean Sire de Joinville) ордоны он дараалалын бичигтээ Монголын талаар тэмдэглэж, санваартан Жан де Лонг (Jean de Long, 1340-1383) судар бичигийн дотороос Монголтой холбогдол бүхий баримт сэлтийг идэвхийлэн цуглуулж байсан тухай тодорхой мэдээ буй.

Үүнтэй харьцуулахад монгол хэлний тухайд харьцангуй хожуухан анхаарч, монгол хэлний олдсон толь бичигийн хэрэглэгдэхүүний хүрээнд судлах ажил хийж иржээ. Гадаад хүний бичсэн монгол хэлний анхны хэлзүй хэмээн олон хүний бичиж тэмдэглэдэг Я.Шмидт (I. J. Schmidt)-ийн “*Монгол хэлний зүй*” (1831) гарахаас 259 жилийн өмнө буюу 1672 онд бядан явагч Мелчиседек Тевено (Melchisedech Thevenot, 1620-1693) гэдэг хүний “*Монгол хэлний зүйн найруулал*” [L'essais de la grammaire mongole] францад гарсан нь чухамдаа өнөөдөрийн бидний мэдэх хэмжээнд гадаад хүний бичсэн монгол хэлзүйн анхны бие даасан бүтээл бөлгөө. Зохиогч энэхүү хэлзүйгээ түрэг-монгол толь зэрэг араб бичигээрхи хэрэглэгдэхүүнд тулгуурлан бичсэн бөгөөд уг бүтээлийн талаар Финляндын монголч эрдэмтэн П. Аалто (P. Aalto) профессор 1963 онд тусхай өгүүлэл бичсэн билээ. Хэдийгээр энэхүү хэлзүйн бүтээлийг Я. Шмидт зэрэг гурван зуу шахам жилийн дараахи мэргэжилийн эрдэмтэдийн “бүрэн” хэлзүйтэй харьцуулахад судлагааны баримт хязгаарлагдмал, хэрэглээний тал руу түлхүү анхаарсан байдалтай боловч, цаг хугацаа, орон зайн бололцоог нь харгалзах бөгөөс өөлөн шүүмжлэх эрх бидэнд үгүй, харин ч анхны хэлзүйн ном туурвисанд нь бид гүнээ талархах ёстой бөлгөө.

Бас 1820 онд Францын нэрт түүхч Абэль Ремюза (Abel Remusat 1788 -1832) “*Татаруудын хэлний судлагаа буюу эргэцүүлэл*” [Recherches sur les langues Tartares ou memoires] гэдэг хэдэн зуун хуудас томоохон бүтээлээ Парис хотноо хэвлүүлж, монгол хэлний гарал, монгол хэлний уламжлалт хэлзүйн бүтээл, монголчуудын хэрэглэж ирсэн олон үсэг бичигийн талаар тодорхой өгүүлж, монголоос гадна хятад, төвөд, манж, зөрчид, солонгос зэрэг Төв Ази дахины бусад ард түмэний хэл, бичигийг танилцуулжээ. 1866 онд Л. Фейер (Leon Feer) Францын Гоо Филиппэд Ил хаан Аргунаас илгээсэн захидалын хэлийг судлан монгол бичигийн хэлний зүйг хялбар байдлаар хүснэгтлэн хэвлүүлсэн байна.

XVIII-XIX зуун гэхэд Францад Монголын түүхэнд шууд холбогдох судлагааний бүтээл шил шилээ даран гарчээ. 1756-1758 онд Парис хотноо Дэгини (Deguignes)-ийн дөрвөн боть, таван дэвтэр “*Хүн(нү), Түрэг, Монголчууд болон бусад өрнөд Тартаруудын ерөнхий*

түүх” [*Histoire générale des Huns, des Turks, des Mongols et des autres Tartares occidentaux*] хэмээх томоохон бүтээл гарчээ. Мөн П. Бержерон (P. Bergeron), Пети де Ла Крва (Petis de la Croix), Антуан Губил (Antoine Gaubil), Жозеф де Майя (Joseph de Mailla), Д’Авезак (D’Avezac), Д’Оссон (D’Osson), Э. Катрмэр (E. Quatrmere), Хюк (Нус), Л. Фейер (Leon Feer), Э. Друэн (E. Drouin) зэрэг францын түүхчид, П. Карпин, Г. Рүбрүкийн замын тэмдэглэл хийгээд Жүвейн, Рашид Ад-дины түүх, перс, латин, армян, нангиад түүхэн дэхи холбогдох баримт сэлтийг орчуулах, тухайн хэрэглэгдэхүүнд түшиглэн нэг болон олон ботит түүх бичиж нийтийн хүртээл болгосон байдаг. Бас Роланд Бонапарт “XIII- XIV зууны Монголын үеийн дурацхалууд” [Prince Roland Bonaparte, *Documents de l’époque mongole des XIIIe et XIVe siècles, Paris, 1896*] хэмээх олон ховор баримт хэрэглэгдэхүүний гэрэл зурагийн цомог гаргасан нь орон ороны монголч эрдэмтэдэд тэдгээр сурвалжийг уг эхээс нь судлах таатай боломжийг буй болгосон юм.

Чухам энэхүү бэлэдхэл үед Чингис хаан болон түүний байгуулсан Их Монгол Улсыг онцгойлон анхаарч францын судлаачидын цуглуулсан монголчуудын түүх, хэл, соёлд холбогдох гол хэрэглэгдэхүүн нь тухайн цагт франц газар харьцангуй олдцотой перс, араб, латин зэрэг хэл бичигээрхи баримт сэлт байсан ажээ. Тэр нь ч зөвхөн францын төдийгүй европын бусад ороны түрүү үеийн монгол судлалд зохих хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэх үндэс буй. Тэгээд ч францын ахмад үеийн монголч эрдэмтэдийн бүтээлийг үзэхэд перс, араб, армян, латин, хятал хэл бичигээрхи хэрэглэгдэхүүн гол сурвалж нь болж, энэ нь ч францад монголын судлалын бие даасан өвөрмиц уламжлалт дэг бүрэлдэн тогтох үндэс болж өгсөн бөлгөө.

1.3.2. Франц дахи монголын судлал (I)

XIX зууны 20-иод онд Францад “*Journal asiatique*” хэмээх эрдэм шинжилгээний тогтмол хэвлэл гаргадаг *Азийн нийгэмлэг* [Société Asiatique] тулгар байгуулагдаж, уламаар *Collège de France*-д Дорнодахиныг судлах тэнхим буй болсон нь Францад монголын судлал эрчимтэй үүсэх өргөн бололцоог буй болгож Католик шашины бядан явагч-элч Хюк [Нус], Габэ [Gabet] нарын дэмжилгээр Төв Азийг судлагч, алдарт эрдэмтэн **Поль Пеллио** [Paul Pelliot²] монголын судлалын эхийг тавьжээ.

Франц дахи монголын судлал нь эхлэсэн үеэсээ түүх, нийгэм, хэл, бичиг, соёл гэх зэрэг монголын судлалын бараг бүх салбарыг жигд хамарч одоог хүрсэн нь аль нэгэн тодорхой чиглэлээр түлхүү хөгжиж ирсэн Европын бусад улс ороны монголын судлалаас ялгарч өгдөг төдийгүй зөвхөн францын төдийгүй бусад ороны залгамж үеийн нэрт монголчидыг бэлэдхэж өгсөнөөрөө онцгой байр эзлэдэг юм. Үүний дээр герман зэрэг европын бусад улсын монголч эрдэмтэдийг нутагтаа үр бүтээлтэй ажиллах таатай боломжийг ч олгосоор иржээ. Тухайлбал: Поль Пеллио-гийн шавь, Юаны хууль цаазыг тусхайлан судлаж дөрвөн боть ном туурвисан германы монголч эрдэмтэн Паул Рачневски (Paul Ratchnevsky, 1899 - 1991) 1922 – 1938 онд Парист ажиллаж байсан бөгөөд гол гол бүтээлээ францаар туурвисан байдаг.

Энэ бүхэнд Франц газар монголын судлалын суурийг буй болгосон, угтаа нангиадын судлалч байсан, жишихийн аргагүй өргөн мэдэлгэтэй, Төв Азийг судлагч Поль Пеллиогийн эрдэм шинжилгээний тал талын судлагаа хийгээд эх нутагтаа Лүй Амби (Louis Hambis,

² Тод хар үсэгээр ялгасан үгийн тухайд бие даасан тусхай зурвас өгүүлэл буй.

1906 - 1978), Эвелин Лот-Фалк (Eveline Lot-Falk 1918 - 1974), Унгарт монголын судлалын эхийг тавьсан Лайош Лигети (Louis Ligeti / Ligeti Lajos, 1902 – 1987), Америкийн Нэгдсэн Улсын Блуумингтон дахи Индиана Их сургуульд Төв Азийн судлалыг үүсгэж, Олон улсын Алтай судлалын Байнгын бага хурал (PIAC)-ыг санаачилан байгуулсан (1960) Денис Синор (Denis Sinor, 1916 -), Монголын Мэргэн гүн хэмээх Гомбожав зэрэг монголын судлалаар дэлхийн олон нэрт эрдэмтэнийг бэлэдхэсэн үйл ажиллагаа нь онцгой байр эзлэдэг юм.

Монголын түүхийн талаар: Рене Грүсэ (Rene Grousset, 1885 - 1952) Аттила, Чингис, Төмөрийн талаар “*Тал нутагийн Их гүрэн*” [L’empire des steppes: Atilla-Gengis Khan-Tamerlan, 1939], “*Монголын Их гүрэн*” [L’empire mongol, 1941], Чингис хааны амьдрал хэмээх давхар гарчиг бүхий “*Ертөнц дахиныг дагуулагч*” [Le conquérant du monde: Vie de Gengis Khan, 1944] зэрэг гурван томоохон бүтээлээ туурвиж тухайн цагтаа Чингис хаан, түүний үйл ажиллагаа, түүхэн үүрэг болон Монгол гүрэний талаар дэлхий нийтэд бодтай танилцуулах үүдийг европод анх нээжээ. Нэрт монголч-нангиадач эрдэмтэн Поль Пеллио “*Монголын нууц товчоон*”-ы хятад галигийг латинаар сэргээж, францаар орчуулж эхлэсэн боловч гүйцээж завдалгүй ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн боловч нас барсаны нь дараа бүрэн галиг, эхиний зургаан бөлөгийн франц орчуулга нь хэвлэгджээ.

Мөн 1973 онд **Лүй Амби (Louis Hambis, 1906 - 1978)** “*Чингис хаан*” номоо хэвлүүлж, 1985 онд Клод Капплер (Claude Kappler), Рене Капплер (Rene Kappler) нар В. Рубруккийн “*Монгол гүрэнээр аялсан нь*” хэмээх тэмдэглэл-түүхийг францаар орчуулан гаргаж, холбогдох тайлбарыг эрдэм шинжилгээний зохих төвшинд хийсэн байна.

Үүнээс гадна иран-түрэг судлагч Жан Обен (Jean Aubin, 1927 – 1998), латин судлагч Жан Ришар (Jean Richard), араб судлагч Дедиер Газагнаду (Dedier Gazagnadou) зэрэг эрдэмтэд өөр өөрийнхөө судлагаатай холбож монголын түүхэнд урьд өмнө мэдэгдээгүй байсан олон шинэ баримт хэрэглэгдэхүүнийг тулгар гарган танилцуулсан олон өгүүлэл бүтээл нийтлүүлсэнийг дурадалгүй өнгөрөх аргагүй. Тухайлбал: профессор Жан Ришар “*1262 онд Парист очсон нэгэн монгол элчин*” (Une ambassade mongole à Paris en 1262, - *Journal des Savants*, Paris, 1979, pp. 295-3003) гэдэг өгүүлэлдээ Вена хотын номын сангаас олдсон, ил хаан Хүлэгүгээс Францын хаан IX Лүйд хандан холбоотон болж өгөхийг хүсч бичсэн нэгэн захидалыг судлан эрдэм шинжилгээний эргэлтэнд шинээр оруулсан байдаг.

Монгол хэл, бичигийн талаар: нэрт эрдэмтэн Поль Пеллиогийн гарын шавь Лүй Амби монгол бичигийн хэлийг голлон судлаж, зааж байсан боловч түүний хажуугаар Монгол болон Төв Азийн түүх соёлын судлалаар багшийнхаа дэг сургуулийг үргэлжлүүлэн хөгжүүлсэн гэдэгийг тэмдэглэвэл зохино.

Мөн францын нэрт түрэгч-монголч, соёл судлагч Лүй Базен (Louis Bazin) үгийн сангийн хүрээнд монгол хэлтэй харьцуулсан олон бүтээл гаргасанаас гадна “Алтайн онол”-ыг эргэн нягтлахдаа монгол хэлний хэрэглэгдэхүүнийг өргөн ашигласан байдаг юм. Мөн П. Пеллиогийн шавь, хятад-монгол хэл судлагч Алексис Рыгалов (Alexis Rygaloff)-ын ажил ч энд хамаарна.

Зан заншил, шашин сурталын талаар: Сибирийн олон ард түмэний бөө мөргөлийг нарийвчилан судласан Э. Лот-Фалк (E. Lot-Falk, 1918 - 1974) монголчуудын угсаатаны зүй, уламжлалт шашиныг судлах эхлэлийг тавьж энэ чиглэлээр хүмүүнсудлалч Роберт Амайон (Roberte Hamayon) зэрэг нэртэй шавь-эрдэмтэнийг бэлэдхэн гаргажээ. Угсаатаны зүйн

чиглэлээр бусад эрдэмтэд ч анхааран судласан зүйл олон буй. Тухайлбал: хятадач Ф. Саббан (Françoise Sabban / Françoise Sabban-Serventi) хүнс хоолны судлагаандаа Юан гүрэний үед Монголчуудын нөлөө хэрхэн туссаныг тодруулан гаргажээ.

1. 3. 3. Франц дахи монголын судлал (II)

1963 онд Франц Монгол Улс хоёрын хооронд дипломат харилцаа тогтоосон нь Франц дахи монголын судлалын хөгжилд цоо шинэ үеийг нээн өгсөн юм. Энэ үеэс Францын монголч эрдэмтэд Монгол Улсад ажиллаж монголчуудын бодат амьдралтай танилцах, судлагааны хэрэглэгдэхүүн цуглуулах таатай бололцоо гарах болж хятадач, хуульч **Франсуаз Обен (Françoise Aubin)**, антропологич Роберт Амайон (Roberte Hamayon) нар удаа дараа Монголд ажиллаж, Францын Дорно дахины Хэл Иргэншилийн Дээд сургууль (Institut National des Langues et Civilisations Orientales -INALCO)-д монгол хэлний анги нээхэд 1968 - 1973 онд Р. Амайон, 1973 оноос **Жак Легран (Jacques Legrand)** нар багшлаж, Монгол Улсын Их сургуульд франц хэл албан ёсоор зааж эхлэв. Мөн хоёр улсын монголч эрдэмтэдийн хамтын ажиллагаа ч хөгжих нөхцөл бүриджээ.

Энэ бүхэний дүнд 1969 онд профессор Р. Амайоны хүчин зүтгэлээр Францад **Монголын судлалын Төв [Centre d'études mongoles]** байгуулагдаж, уг төв 1970 оноос эрдэм шинжилгээний жил тутамын сэтгүүл "**Монголын судлал...**" [1970 оноос: "**Etudes mongoles**" > 1976 оноос: "**Etudes mongoles... et sibériennes**" / "**Etudes mongoles et sibériennes**" > 2004 оноос: "**Etudes mongoles et sibériennes, centrasiatiques et tibétaines**"] болон 1991 оноос олон нийтэд зориулсан улирал тутамын "**Анда**" [Anda] хэмээх мэдээлэлийн сэтгүүлийг тогтмол гаргах болсон байна. Энэхүү Төвийн үйл ажиллагааны дүнд Франц дахи монголын судлалын хүрээ өргөжиж монгол хэл, үгсийн сан, угсаатаны зүй, түүхийн салбарт Чой. Лувсанжав, Ц. Шагдарсүрэн, Ц. Сүхбаатар зэрэг Монголын эрдэмтэдтэй хамтран ажиллах болжээ.

Францын Монголын судлалын Төвийн эрдэмтэд энэ хугацаанд орчин цагийн монгол хэл, монгол-франц толь, бөөгийн судлал, угсаатаны зүй зэрэг өргөн чиглэлээр эрчимтэй ажиллаж иржээ. Тухайлбал: нарийн өвөрмиц аргаар бичсэн "**Монгол хэлний зүй**" (Mari-Lise Beffa, R. Hamayon, *Éléments de grammaire mongole*, 1975), "**Монгол хэлний сурах бичиг**" (M-L. Beffa, R. Hamayon, Ce. Suxbaatar, *Manuel de langue mongole*, 1975 /1978) хэвлэгдэж, Р. Амайон (R. Hamayon), **Мари-Доминик Эвэн (Mari-Dominique Even)**, **Мари-Лизе Беффа (Mari-Lise Beffa)** нар Ц. Шагдарсүрэнгийн оролцоотойгоор 30 000 үгтэй "**Монгол франц толь**" зохиожээ. С. Бадамхатан, Б. Ринчен нарын судлагааны ном бүтээлийг орчуулан нийтлэх ажил эхлэж хууль цааз, угсаатаны зүйн салбарт Ф. Обен (F. Aubin), монгол хэл, түүх нийгэм судлалын чиглэлээр Жак Легран (J. Legrand) зэрэг эрдэмтэдийн олон ном өгүүлэл нийтлэгдэн гарлаа. Монголын судлалын Төв байгуулагдсанаар Франц дахи монголын судлал эрдэм шинжилгээний хувьд тодорхой зохион байгуулалтад орсон юм.

Франц Монгол хоёр ороны хооронд 1965 онд дипломат харилцаа тогтож, 1968 онд соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны гэрээ байгуулсаны дараахин Францын Гимэ музей (Musée Guimet)-н ажилтан Александр Эгли (Alexandre Egly) авгайн санаачилгаар 1969 онд Франц Монголын холбоо (Association Française Mongole) байгуулагдан, гишүүд болон сонирхогчидыг Монгол оронтой танилцуулах. Олон Улсын Монголч эрдэмтэний удаа

дараагийн Их хуралд төлөөлөгчидөө оролцуулах зэрэг үйл ажиллагаа эрхилэх болжээ. Энэ хугацаанд Александр Эгли монголын урлаг, эртний уран барилга судлаж өгүүлэл нийтлүүлсэнээс гадна Сара Дарс (Sarah Dars) Монголын эрт эдүгээг франц хэлт олон нийтэд танилцуулсан “Монгол” (Mongolie, Paris, 1979) гэдэг номоо гаргасан юм.

1.3.4. Франц дахи монголын судлал (III)

1990 оноос Монгол орон улс төрийн ардчилсан, нээлттэй тогтолцоонд шилжисэн нь Франц дахи монголын судлал болон францын монголч эрдэмтэдэд илүү таатай нөхцөл боломж бүрдүүлж өгсөн юм. Энэ үеэс Баруун Европын нэлээд ороны монголын судлалын байгуулга санхүү эдийн засагийн хувьд харьцангуй бэрхшээлтэй тулгарсан бол Францын монголч эрдэмтэдийн хүчин зүтгэл, нэр нөлөөгөөр хуучин уламжлалаа хадгалах төдийгүй улам өргөжиж байгааг хэлэх хэрэгтэй. Үүний зэргэцээ франц монголын түүхэн харилцаа, Чингисийн үеийн “Их засаг” зэрэг монголын хууль цааз болон шашин сурталын асуудалыг Дундад Азийн холбогдох судлагдахуунтай харьцуулан Денис Эгле (Denise Aigle), ХБНГУ-д ажиллах болсон монголын нийгэм, бүддийн шашин болон төвөдийн судлалаар Доминик Дюма (Dominique Duma / Dominique Duma-Hansen), монголын шашин сүм хийдийн талаар Изабел Шарлө (Isabelle Charleux) зэрэг олон эрдэмтэн монголын судлалд эрчимтэй орж ирлээ. Ялангуяа Дунд Ази дахины соёл, шашиныг судлагч бөгөөд Ил хаадын улсын талаар профессор Жан Обентай хамтран ажиллаж байсан, Сорбоны Их Сургуулийн профессор Денис Эгле (Denise Aigle) сүүлийн үед монголын түүхчидийн нарийвчилан үзэж амжаагүй Ил хаадын Улс болон Монголын эзэмшил дэхи Перс, Ираны түүх, соёл, гадаад харилцааны асуудалыг араб, перс, сири зэрэг дундад азийн хэл хийгээд латин хэлээрхи сурвалжийг судлаж хэд хэдэн том бүтээл, олон өгүүлэл нийтлүүлсээр байгааг онцлон дурадвал зохино.

Тэгээд ч хуучин Парис хотод голлон төвлөрч байсан монголыг судлах үйл ажиллагаа Нансы (Nancy), Лие (Lille), Түүр (Tour), Страсбург (Strasbourg) зэрэг бусад томоохон хотын их дээд сургуулиудад угсаатны зүй, шашин суртал, монгол ардын дуу хөгжим гэх зэрэг монголын судлалын аль нэгэн салбараар хүрээгээ тэлж, харьцангуй залуу эрдэмтэд монголыг сонирхон судлаж, судлагааны өгүүлэл, бие даасан томоохон бүтээл олоноороо гарсаар байна. Энэ хэр хэлшинжлэл, шашин судлал, угсаатаны зүйн салбарт Мари-Доминик Эвен Нансы хотноо, монгол ардын хөгжимийн уламжлалаар Алэн Дөжак (Alain Desjacques) Лие хотноо, угсаатаны зүй, монгол нүүдэлчидийн өдөр тутамын аж төрөл, уламжлалт баяр, түүний хувирал болон цагаан идээний талаар Изабел Бианки-Кассетари (Isabelle Bianquis-Cassetari) Түүр хотноо үр бүтээлтэй ажиллаж байна. 1991 онд Монгол Улсын Их Сургуульд Монголын Судлалын Хүрээлэн анх байгуулагдаж гадаадын залуу монголчидыг дэмжих зорилго бүхий ахмад гурван академичийн нэрэмжит тэтгэлгийг буй болгосон бөгөөд Б. Ринчений нэрэмжит тэтгэлгээр МУИС-д анх сурч байсан угсаатаны зүй, нийгэм судлалч Гаэл Лаказ (Gaëlle Lakaze) нийгэм-угсаатаны зүйн чиглэлээр зэрэг хамгаалаад одоо Страсбург хотын Их сургуульд ажиллаж, саяхан олон нийтэд зориулсан “Монгол, сүүдэр гэрэлийн орон” (Mongolie, Pays d’ombres et de lumières, Paris, 2006) гэдэг олон зураг бүхий номоо гаргажээ.

Үүнээс гадна мэдээлэлийн “Анда” сэтгүүлийг анх гарахаас нь идэвхитэй оролцож ирсэн, монголыг судлагч Ж. Тевене (J. Thevenet) “Монгол орон” (La Mongolie, Paris, 1999), Монголд удаа дараа ажиллаж асан К. Сэрмие (C. Sermier) “Тал нутагийн гүрэн – Монгол”

(Mongolie, l'Empire des Steppes, Genève, 2000) гэдэг ном, гэрэл зурагийн цомогоо франц хэлтэнд зориулан ойрмогхон Франц, Швейцарид хэвлүүлсэн байна.

Энэ хугацаанд Францын Монголын Судлалын Төвийн үйл ажиллагаа улам идэвхижиж Марие-Доминик Эвен (Marie-Dominique Even) Румыны монголч Родика Поп (Rodica Pop)-ын хамт “Монголын нууц точоон”-ны франц бүрэн орчуулгыг анх (1994) гаргаж, БНХАУ-дахи монголчуудын хэл, угсаатаны зүй, шашин судлалын талаар үлэмжхэн хэрэглэгдэхүүн цуглуулж, Олон Улсын Алтайсудлалын Байнгын бага хурал (PIAC)-ын 37-р чуулганыг Францын Шантье (Chantille) хотноо (1994) зохион байгууллаа. Мөн Марие-Лизе Беффа (Marie-Lise Beffa) Францын Хүний музей (Musée de l'Homme)-н ажилтан, сибирийг судлагч Лоренс Делабы (Laurence Delaby) нар тус музейн хөмрөг дэхи холбогдох эд өлөгийн зүйлийг бүридхэх, судлах ажилыг хийж байна.

Энэ хугацаанд монголын судлалд шууд холбогдох олон бүтээл гарсаар ирсэн бөгөөд үүнд шашины түүхийг харьцуулан судлагч, түүхч Жан Поль Рүү (Jean Paul Roux)-гийн “Түрэг Монголчуудын шашин шүтэлгэ” (La religion des Turks et des Mongols, 1984), “Бабур буюу Их Моголын түүх” (Babur, Histoire des Grands Moghols, 1986), “Төмөр” (Tamerlan, 1991), “Монгол гүрэний түүх” (Histoire de l'Empire mongol, 1993) гэдэг томоохон бүтээлүүд давын өмнө хамаарна. 2006 оны эцэсээр И. Шарлэ 100-аад гэрэл зураг бүхий “Өвөр Монголын сүм хийд” (Isabelle Charleux, *Temples et monastères de Mongolie-Intérieure*, ed. de CTHS, 2006, 450 p.) гэдэг томоохон номоо гаргалаа. Мөн Төв Азийг судлах хүрээнд монголтой шууд холбогдол бүхий Дундад зуунаас ХХ зуун хүртэл Монгол газар удаа дараа ирсэн жуулчидын тэмдэглэлийг сорлон товчоолсон Мишел Жан (Michel Jan)-ы эмхидхэл зэрэг нэг бус бүтээл гарсаныг тэмдэглэвэл зохино.

Мөн Л. Амби (L. Hambis), Ж. Легран (J. Legrand) зэрэг эрдэмтэдийн Чингис хаан болон Монголын талаархи ном нь япон, португали зэрэг хэлээр орчуулагдан гарч тухайн ороны уншигчидыг Монголтой танилцуулах гүүр болсоор ирсэн бөлгөө.

Ийнхүү Европ дахинд хамагийн анх буюу XIII зуунд францчуудын санаачилгаар анх үүссэн франц дахи монголын судлал өвөрмиц уламжлалаа хадгалан, Ив Доремийө (Yves Dorémieux), Грегори Дөлаплас (Grégoire Delaplace) зэрэг залуу үеийнхинээр бүрэлдэхүүнээ тогтмол сэлбэж, өнөөдөрийг хүртэл өргөжин хөгжисөөр байна.

Хамагийн сүүлд хэлэлгүй орхиж болохгүй нэгэн зүйл: Монголчуудын шинжлэх ухааны сэтгэлгээ тоозүй буюу математик, уран барилга, дүрслэх урлаг зэрэг нэг бус салбарт тухай тухайн үедээ багагүй нөлөөтэй байсаар ирсэн тул францын мэргэжилийн эрдэмтэдийн бүтээлд тэр талаар дурадсан зүйл цөөнгүй. Нэгэн жишээ: нангиадын тоозүйн ухааны түүхийг судладаг эрдэмтэн Жан-Клод Марццлофф (Jean-Claude Martzloff) “Хятадын математикийн түүх” (*Histoire des Mathématiques chinoises*, Masson, Paris, 1987, 376 p.) хэмээх томоохон бүтээлдээ монголын их тоозүйч, хятадаар Ming Antu (明安圖) хэмээгч Мянгат (1685 – 1769/1770)-ын судлагааны талаар холбогдох сэдэв бүрээр нь тодорхой оруулсанаас гадна олон өгүүлэлдээ баримтаар дурадсан нь буй.



Поль Пеллио (Paul Pelliot)



Лүй Амби (Louis Hambis)